СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн  Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/208-НА-СТА-ТШЗ


Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор:  Ч.Энхтуяа
Утас: 70363040    Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер:   Б.Батмөнх
Утас: 70363036    Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Аудитор:    Ч.Цэрэннадмид
Утас: 95112689    Цахим хаяг: ts.nadiii@yahoo.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт…....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.... 5
2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.... 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.... 11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.... 11
3.Аудитын тайлан.... 14
3.1. Ерөнхий зүйл.... 14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.... 14
3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал ....14
3.4. Материаллаг байдал .... 14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.... 16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.... 17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .... 17
3.8 Аудитын гол асуудал .... 177
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.... 18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.... 18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .... 18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.... 18
4.2 Албан шаардлага, зөвлөмж.... 18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| БСГ | Боловсрол соёлын газар |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/208-НА-СТА-ТШЗ

танай ________________-ны № ________________-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААННУУР СУМЫН
2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
З.СЭЛЭНГЭ ТАНАА

# АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

## Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.



018020179

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **30,827,281.00** | **40,005,327.00** |
| 31 | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө** | - | - |
| 311 | **Кассанд байгаа** | - | |
| 312 | **Банкинд байгаа** | | |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **30,827,281.00** | **40,005,327.00** |
| 351 | Түүхий эд материал | - | **156,500.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | |
| 35130 | Эм боох материал | - | 156,500.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | | |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | | |
| 354 | **Хангамжийн материал** | **30,827,281.00** | **39,848,827.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 39,500.00 | 39,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 28,942,087.00 | 37,480,987.00 |
| 35460 | Хүнсний материал | | 318,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,845,694.00 | 2,010,240.00 |
| 356 | **Мал амьтад** | - | - |
| 36 | **НӨӨЦИЙН БАРАА** | | |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,965,657,441.54** | **1,921,833,518.20** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,965,657,441.54** | **1,921,833,518.20** |
| 392 | **Биет хөрөнгийн дүн** | **1,965,657,441.54** | **1,917,639,518.20** |
| 39201 | Барилга байгууламж | 1,899,817,956.00 | 1,899,817,956.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (3,416,317.41) | (44,412,126.33) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж | 25,747,993.00 | 34,910,293.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (2,268,186.57) | (10,227,184.71) |
| 39207 | Тавилга, эд хогшил | 45,467,941.80 | 45,467,941.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (3,308,581.45) | (11,291,411.77) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,500,860.00 | 3,500,860.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (29,173.83) | (379,259.79) |
| 39217 | Ном | 144,950.00 | 252,450.00 |
| 393 | **Биет бус хөрөнгийн дүн** | - | **4,194,000.00** |
| 39301 | Программ хангамж | - | - |
| 39302 | Хасагдуулга | - | - |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | - | 4,194,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,996,484,722.54** | **1,961,838,845.20** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,996,484,722.54** | **1,961,838,845.20** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,996,484,722.54 | 1,961,838,845.20 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал | - | 4,194,000.00 |
| 51101 | Өмч: -төрийн | - | 4,194,000.00 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | **1,996,484,722.54** | **1,957,644,845.20** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,996,484,722.54 | 1,996,484,722.54 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (38,839,877.34) |
| 51300 | Дахин үнэлгээний зөрүү | - | - |
| 6 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН** | **1,996,484,722.54** | **1,961,838,845.20** |

## 2.2 *Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **2,386,550,789.80** | **423,559,773.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,005,296,824.80** | **6,353,596.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **2,005,296,824.80** | **6,353,596.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | **2,005,296,824.80** | **6,353,596.00** |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 11,670,087.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,967,654,500.80 | 3,044,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 25,972,237.00 | 3,309,596.00 |
| **13** | **ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **381,253,965.00** | **417,206,177.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **352,834,400.00** | **390,605,000.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 352,834,400.00 | 390,605,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **297,600.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 297,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **28,419,565.00** | **26,303,577.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,419,565.00 | 26,303,577.00 |
| **2** | **Үйл ажиллагааны зардал** | **378,395,980.26** | **462,399,650.34** |
| **21** | **Урсгал зардал** | **378,395,980.26** | **462,399,650.34** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **346,807,179.42** | **447,497,555.01** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал** | **240,296,428.00** | **293,839,143.00** |
| 210101 | Үндсэн цалин | 174,678,160.00 | 187,849,233.00 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 45,187,668.00 | 81,441,272.00 |
| 210104 | Урамшуулал | 20,430,600.00 | 20,357,700.00 |
| 210105 | Гэрээтийн цалин | | 4,190,938.00 |
| **2102** | **Нийгмийн даатгалын шимтгэл** | **30,711,421.16** | **39,615,061.67** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын | 20,889,014.80 | 27,488,263.43 |
| 210202 | тэтгэмжийн даатгалын | 2,457,089.42 | 3,093,538.20 |
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын | 1,965,670.30 | 2,381,232.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын | 485,467.80 | 592,282.37 |
| 210205 | ЭМ-ийн даатгалын | 4,914,178.84 | 6,059,745.40 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **28,419,565.00** | **23,126,577.00** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 4,816,347.00 | 4,748,637.00 |
| 210302 | Түлш,халаалтын зардал | 20,292,618.00 | 11,055,690.00 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 3,310,600.00 | 7,322,250.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,814,606.00** | **4,378,900.00** |
| 210401 | Бичиг хэргийн зардал | 241,100.00 | 147,900.00 |
| 210404 | Тээвэр шатахуун | 313,356.00 | 292,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн зардал | - | 1,019,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | . |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 967,944.00 | 886,800.00 |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал | 2,292,206.00 | 2,032,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | - |
| **2105** | **Нормативт зардал** | **18,631,450.00** | **20,275,700.00** |
| 210502 | Хоол, хүнс | 18,562,050.00 | 20,225,700.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 69,400.00 | 50,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,528,400.00** | **3,896,400.00** |
| 210601 | Багаж техник, хэрэгсэл | | - |
| 210604 | Урсгал засварын зардал | 8,528,400.00 | 3,896,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолтын зардал** | **110,000.00** | **151,100.00** |
| 210702 | Дотоодын томилолт | 110,000.00 | 151,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс** | **1,992,400.00** | **1,052,500.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 418,400.00 | 566,500.00 |
| 210802 | Аудит баталгаажуулалтын зардал | 324,000.00 | 486,000.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 1,250,000.00 | |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх | | |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| **2109** | **Бараа, үйлчилгээний бусад зардал** | **14,302,909.26** | **61,162,173.34** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 955,900.00 | |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 4,324,750.00 | 3,874,450.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 9,022,259.26 | 57,287,723.34 |
| **213** | **Урсгал шилжүүлэг** | **31,588,800.84** | **14,902,095.33** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **-** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **31,588,800.84** | **14,902,095.33** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 31,588,800.84 | 14,902,095.33 |
| **3** | **Үйл ажиллагааны үр дүн** | **2,008,154,809.54** | **(38,839,877.34)** |
| **145** | **Үйл ажиллагааны бус орлогын дүн** | | |
| **225** | **Үйл ажиллагааны бус зардлын дүн** | | |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **-** |
| 225001 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө | - | |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал | - | |
| **4** | **Үйл ажиллагааны бус үр дүн** | - | - |
| **5** | **Үйл ажиллагааны нийт үр дүн** | **2,008,154,809.54** | **(38,839,877.34)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | ***ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ*** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **381,253,965.00** | **417,206,177.00** |
| **13** | **ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **381,253,965.00** | **417,206,177.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **352,834,400.00** | **390,605,000.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 352,834,400.00 | 390,605,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **297,600.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 297,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **28,419,565.00** | **26,303,577.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,419,565.00 | 26,303,577.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **374,340,965.00** | **410,980,377.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **374,340,965.00** | **410,980,377.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **342,752,164.16** | **396,078,281.67** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал** | **240,296,428.00** | **293,839,143.00** |
| 210101 | Үндсэн цалин | 174,678,160.00 | 187,849,233.00 |
| 210102 | Нэмэгдэл | 45,187,668.00 | 81,441,272.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | - |
| 210104 | Урамшуулал | 20,430,600.00 | 20,357,700.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 4,190,938.00 |
| **2102** | **Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **30,711,421.16** | **39,615,061.67** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын | 20,889,014.80 | 27,488,263.43 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын | 2,457,089.42 | 3,093,538.20 |
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын | 1,965,670.30 | 2,381,232.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын | 485,467.80 | 592,282.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын | 4,914,178.84 | 6,059,745.40 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **28,419,565.00** | **23,126,577.00** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 4,816,347.00 | 4,748,637.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 20,292,618.00 | 11,055,690.00 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 3,310,600.00 | 7,322,250.00 |
| **2104** | **Хангамж, бараа материал** | **3,840,000.00** | **3,361,700.00** |
| 210401 | Бичиг хэргийн зардал | 280,600.00 | 147,900.00 |
| 210404 | Тээвэр шатахуун | 261,300.00 | 294,000.00 |
| 210403 | Шуудан холбооны зардал, мэдээлэл тех-гийн үйлчилгээ | - | 1,019,800.00 |
| 210404 | Ном | 112,200.00 | - |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 1,490,000.00 | 953,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,695,900.00 | 946,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **25,161,650.00** | **26,630,300.00** |
| 210501 | Эм | 69,400.00 | 94,300.00 |
| 210502 | Хоол,хүнс | 18,562,050.00 | 20,543,800.00 |
| 210503 | Нормын хувцас | 6,530,200.00 | 5,992,200.00 |
| **2106** | **Эд хогшил урсгал засвар** | **9,665,400.00** | **4,878,100.00** |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 777,000.00 | 981,700.00 |
| 210602 | Тавилга | 360,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 8,528,400.00 | 3,896,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **110,000.00** | **151,100.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоодын томилолт | 110,000.00 | 151,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,992,400.00** | **1,052,500.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил , үйлчилгээний төлбөр, хураамж | 418,400.00 | 566,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 486,000.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 1,250,000.00 | |
| 210807 | Газрын төлбөр | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,555,300.00** | **3,423,800.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 955,900.00 | - |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,599,400.00 | 3,423,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **31,588,800.84** | **14,902,095.33** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **-** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| **2133** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт** | **31,588,800.84** | **14,902,095.33** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 31,588,800.84 | 14,902,095.33 |
| **22** | **Хөрөнгийн зардал** | **-** | **-** |
| **2220** | **Дотоод эх үүсвэрээр** | **-** | **-** |
| 222001 | Тоног төхөөрөмж | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | |
| 225107 | Тоног төхөөрөмж | | |
| 225108 | Бусад хөрөнгө | | |
| **3** | **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **6,913,000.00** | **6,225,800.00** |
| | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| **4** | **Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн** | | |
| **5** | **Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн** | **7,025,200.00** | **6,225,800.00** |
| **22** | **Хөрөнгийн зардал** | **7,025,200.00** | **6,225,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **7,025,200.00** | **6,225,800.00** |
| | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | |
| 222001 | Тоног төхөөрөмж | 3,273,000.00 | 6,118,300.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 3,752,200.00 | 107,500.00 |
| **6** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(7,025,200.00)** | **(6,225,800.00)** |
| **7** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | | |
| 8 | **Нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | **(112,200.00)** | **-** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны үр дүн |
|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 |
| **2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **1,996,484,722.54** | **1,996,484,722.54** |
| НББ-ийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | - |
| ҮХ-ийн өсөлт, бууралт | | | | - |
| ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | - | - |
| **2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **1,996,484,722.54** | **1,996,484,722.54** |
| НББ-ийн бодлогын өөрчлөлт | | | - | - |
| ҮХ-ийн өсөлт, бууралт | | - | | - |
| ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт | 4,194,000.00 | | | **4,194,000.00** |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | (38,839,877.34) | **(38,839,877.34)** |
| **2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,194,000.00** | **-** | **1,957,644,845.20** | **1,961,838,845.20** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 428,367,900.00 | 402,006,481.67 | 26,361,418.33 | 93.8 |
| 21 | Урсгал зардлын дүн | 428,367,900.00 | 402,006,481.67 | 26,361,418.33 | 93.8 |
| 210 | Бараа үйлчилгээний зардал | 428,367,900.00 | 395,780,681.67 | 32,587,218.33 | 92.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 298,307,700.00 | 293,839,143.00 | 4,468,557.00 | 98.5 |
| 210101 | Үндсэн цалин | 209,147,900.00 | 187,849,233.00 | 35,914,395.00 | 89.8 |
| 210102 | Нэмэгдэл | 50,802,100.00 | 81,441,272.00 | (30,639,172.00) | 160.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | - | |
| 210104 | Урамшуулал | 20,357,700.00 | 20,357,700.00 | - | 100.0 |
| 210105 | Гэрээт ажилтан | 18,000,000.00 | 4,190,938.00 | 13,809,062.00 | 23.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 39,820,200.00 | 39,615,061.67 | 205,138.33 | 99.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,887,800.00 | 27,488,263.43 | 399,536.57 | 98.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,983,100.00 | 3,093,538.20 | (110,438.20) | 103.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,386,500.00 | 2,381,232.27 | 5,267.73 | 99.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 596,600.00 | 592,282.37 | 4,317.63 | 99.3 |
| 210205 | ЭМД-ын хураамж+В21 | 5,966,200.00 | 6,059,745.40 | (93,545.40) | 101.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 34,585,900.00 | 23,126,577.00 | 11,459,323.00 | 66.9 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 11,900,000.00 | 4,748,637.00 | 7,151,363.00 | 39.9 |
| 210302 | Түлш,халаалтын зардал | 14,945,900.00 | 11,055,690.00 | 3,890,210.00 | 74.0 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 7,740,000.00 | 7,322,250.00 | 417,750.00 | 94.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,171,600.00 | 3,064,100.00 | 107,500.00 | 96.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 147,900.00 | 147,900.00 | - | 100.0 |
| 210402 | Тээвэр шатахуун | 294,000.00 | 294,000.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан холбоо | 1,019,800.00 | 1,019,800.00 | - | 100.0 |
| 210404 | Ном | 107,500.00 | - | 107,500.00 | 0.0 |
| 210405 | Хог хаягдал | 656,200.00 | 656,200.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл | 946,200.00 | 946,200.00 | - | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 36,370,500.00 | 26,630,300.00 | 9,740,200.00 | 73.2 |
| 210501 | Эм | 94,300.00 | 94,300.00 | - | 100.0 |
| 210502 | Хоол хүнс | 30,283,800.00 | 20,543,800.00 | 9,740,000.00 | 67.8 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 5,992,400.00 | 5,992,200.00 | 200.00 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,996,400.00 | 4,878,100.00 | 6,118,300.00 | 44.4 |
| 210601 | Багаж хэрэгсэл | 7,100,000.00 | 981,700.00 | 6,118,300.00 | 13.8 |
| 210602 | Тавилга | | | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | | | - | |
| 210604 | Урсгал засвар | 3,896,400.00 | 3,896,400.00 | - | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 151,100.00 | 151,100.00 | - | 100.0 |
| 210702 | Дотоод томилолт | 151,100.00 | 151,100.00 | - | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 1,540,700.00 | 1,052,500.00 | 488,200.00 | 68.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 568,700.00 | 566,500.00 | 2,200.00 | 99.6 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 972,000.00 | 486,000.00 | 486,000.00 | 50.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,423,800.00 | 3,423,800.00 | - | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | | - | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,423,800.00 | 3,423,800.00 | - | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | - | - | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох | - | - | - | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | | - | |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | - | - | |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | | - | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 6,225,800.00 | (6,225,800.00) | |
| | Дотоод эх үүсвэрээр | | | - | |
| | Тоног төхөөрөмж | | 6,118,300.00 | (6,118,300.00) | |
| | Бусад хөрөнгө | | 107,500.00 | (107,500.00) | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 428,367,900.00 | 416,908,577.00 | 11,459,323.00 | 97.3 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 390,605,000.00 | 390,605,000.00 | - | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | | - | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 390,605,000.00 | 390,605,000.00 | - | 100.0 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 37,762,900.00 | 26,303,577.00 | 11,459,323.00 | 69.65 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 37,762,900.00 | 26,303,577.00 | 11,459,323.00 | 69.65 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | | - | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | | - | |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | | | - | |
| 001 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | - | |
| 002 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 003 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| | АЖИЛЛАГСДЫН ТОО | 30.00 | 30.00 | - | 100.0 |
| | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 10.00 | - | 100.0 |
| | Үйлчлэх ажилтан | 19.00 | 19.00 | - | 100.0 |
| 010 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /ЖИЛИЙН ДУНДЖААР/ | 182.00 | 144.00 | 38.00 | 79.1 |
| 015 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 182.00 | 144.00 | 38.00 | 79.1 |
| 024 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | | | - | |
| 028 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/ | - | - | - | |
| 033 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч | - | - | - | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 297,600.00 | -297,600.00 | |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 297,600.00 | -297,600.00 | |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 297,600.00 | -297,600.00 | |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | | | |
| 210101 | Үндсэн цалин | | | | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | | | |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | | | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 297,600.00 | -297,600.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 297,600.00 | -297,600.00 | |
| 2105 | Нормативт зардал | | | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | | | |
| 2107 | Томилолт, зочны зардал | | | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | | | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | | | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | | | |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | | | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | | | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 297,600.00 | -297,600.00 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 297,600.00 | -297,600.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 297,600.00 | -297,600.00 | |
| | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | | |
| | | | | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн */цаашид Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг гэх/* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримт, шилэн данстай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн захирал аудитор Ч.Цэрэннадмид, аудитор Т.Эрдэнэтуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “ЦЭСБ-Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг нь *“Хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад бүх талуудтай хамтран ажиллая.”* гэсэн зорилготой, тухайн зорилгын хүрээнд 5 зорилт тавин ажилласан байна.

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Хүүхдийн эрхийг дээдэлж, хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэх
- СӨБ-ын өдрийн болон явуулын хувилбарт сургалтаар чанартай олгож, хүүхэд бүрийг бүх талаар хөгжүүлэх
- Эцэг эхийн сурган хүмүүжүүлэх боловсролыг дээшлүүлэх, СӨБ-д олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.
- БШУ-ны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн А/05, А/10, 1 тоот хамтарсан тушаал "Шалгуур үзүүлэлт шинэчлэх тухай" үр чадвар
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- "Нийгмийн даатгалын тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 32 дугаар зүйлийн 2 дугаар зүйл-д-НДШ-ийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 378,395.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,783.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,648.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,645.9 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1:* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Хувь хүнээс авах авлага | | | |
| Татаас санхүүжилтийн авлага | | | |
| Байгууллагаас авах авлага | | - | - |
| Урьдчилж төлсөн зардал | | | |
| Бараа материал | 30,827.3 | 40,005.3 | 9,178.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,965,657.4 | 1,921,833.5 | (43,823.9) |
| **Нийт хөрөнгө** | **1,996,484.7** | **1,961,838.8** | **(34,645.9)** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,996,484.7 | 1,961,838.8 | (34,645.9) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,996,484.7** | **1,961,838.8** | **(34,645.9)** |

Бараа материалын дансны үлдэгдэл 40,005.3 мянган төгрөг болж 9,178.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 46,033.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон БСГ-аас 114.1 мянган төгрөгийн бусад хангамжийн материал /гар халдваргүйжүүлэгч, автомакс/, эцэг, эхчүүдээс 3,030.9 мянган төгрөгийг хангамжийн материал, ДЗОУБ-аас 164.6 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 40,164.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 1,988,143.5 мянган төгрөг болж өмнөх оноос 13,463.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6,118.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 107.5 мянган төгрөгийн ном худалдан авч, БСГ-аас 3,044.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /зөөврийн компютер, суурин компютер/ хандиваар авсан, 4,194.0 мянган төгрөгийн 2097м2 газрыг үнэлж, орлогод хүлээн авснаас голлон шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,961,838.8 мянган төгрөг болж 34,645.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 423,559.8 мянган төгрөг болж өмнөх оноос 1,962,991.0 мянган төгрөгөөр буюу 82.2 хувиар буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 462,399.6 мянган төгрөг болж өмнөх оноос 84,003.7 мянган төгрөгөөр буюу 22,2 хувиар өссөн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 658,746.2 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 230,378.3 мянган төгрөгөөр бууруулж, **428,367.9 мянган** төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр **428,367.9** мянган төгрөгийн төсөв баталснаас 390,605.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 37,762.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 390,605.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 26,303.6 мянган төгрөг нийт 416,908.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 402,006.5 мянган төгрөгийг зарцуулж, 14,902.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **402,006.5** мянган төгрөг буюу 93.8 хувьтай тайлагнагдсан байгаа нь цалин, НДШ-ийн зардал 4,673.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 11,459.3 мянган төгрөг, нормативт зардал 9,740.2мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 6,118.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 488.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгал, халдваргүйжүүлэлтийн зардлын санхүүжилт 224.0 мянган төгрөг төвлөрч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

**1.** БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан "Түр журам журам батлах тухай " тушаалын нэгдүгээр хавсралт "*Короновируст халдварын үед цэцэрлэгийн*

*сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам*"-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроон, 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаанд 428,367.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 402,006.5 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 6.2 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *".....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах"* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 202.5 мянган төгрөгийн албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 13,463.8 мянган төгрөгөөр шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган

баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,298.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 2 зөвлөмж өглөө.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав.

***1. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд***

*1.1 Илрүүлэлт:* Тайлант онд 1,298.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:* Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д "*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*" гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 2 дугаар хавсралтын 6.5 дахь "*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ*" гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

***2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:***

*2.1 Илрүүлэлт:* Шилэн дансанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроон, 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж:* Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3 гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг | 2 | 1,298.9 | - | - | - | - | | | 2 | 1,298.9 |